

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж , Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, мөн хэсгийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.14-т “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна”, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох” гэж тус тус заасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон байна.

Харин парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан, байгууллага буюу нийтлэгээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэх /delegation of power/ нь олон улсын жишиг төдийгүй манай улсын хууль зүйн тогтолцоонд хэвшиж буй ойлголт болно. Парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан, байгууллагад зөвхөн хуулиар шилжүүлдэг бөгөөд хуулиар эрх олгогдсоны дагуу батлах эрх зүйн дэд актын агуулга, хүрээ, хязгаарыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байдаг. Энэхүү эрх зүйн дэд актын зарим тодорхой хэсгийг “захиргааны хэм хэмжээний акт” гэсэн нэршлийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хүрээнд зохицуулж байна.

Захиргааны ерөнхий хуулийг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээс өмнө захиргааны хэм хэмжээний акттай холбоотой харилцааг Засгийн газрын тогтоолоор баталсан журмын хүрээнд зохицуулж байсан байдаг.

Харин Захиргааны ерөнхий хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах эх сурвалж, үндэслэл, актад тавигдах шаардлага, хүчин төгөлдөр болох нөхцөл, түүнийг хянан бүртгэж мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн сангаас сонирхогч этгээдийг мэдээллээр хангах зэрэг харилцааг тодорхой тусгасан хэдий ч захиргааны хэм хэмжээ актыг батлах субъектийг “захиргааны байгууллага” гэсэн нэр томъёоны хүрээнд ерөнхий шинжээр тусган зохицуулсан байдаг.

Монгол Улсын хэмжээнд 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 2400 орчим захиргааны хэм хэмжээний акт улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлдэг зохицуулалттай. Мөн энэхүү захиргааны хэм хэмжээний акт нь хууль тогтоомжид зааснаар нийтлэг байдлаараа дээд шатны байгууллага, захиргааны шүүхийн хяналтад, зарим субъектийн баталсан захиргааны хэм хэмжээний акт Үндсэн хуулийн цэцээр хянагдах боломжтой байдаг. Эрх бүхий этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь шүүх болон Үндсэн хуулийн цэц буюу шүүх эрх мэдлийн байгууллагын хяналтад байх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчим төдийгүй хууль дээдлэх зарчим, хүний эрхийг хамгаалахад өндөр ач холбогдолтой.

Гэвч Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжиж эхэлэхээс өмнөх хууль тогтоох практикт нийтээр заавал дагаж мөрдөх, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй эрх зүйн хэм хэмжээг бий болгох, тогтоох эрх мэдлийг байгууллагын дотоод бүтцийн нэгжид шилжүүлэх явдал бий болсон байдаг. Тухайлбал Улсын Их Хурлын байнгын хороо, дэд хороодод захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулсан шийдвэр гаргах эрх мэдлийг шилжүүлсэн цөөнгүй хуулийн зохицуулалт өнөөдөр ч үйлчилж байна.

Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороо нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохих салбар, чиглэлээр байгуулагдсан хуулийн этгээдийн эрхгүй дотоод бүтцийн нэгж төдийгүй шийдвэр нь шүүх болон Үндсэн хуулийн цэцийн хяналтад байдаггүй, түүнчлэн баталсан шийдвэрийн бүртгэлийн сан байхгүй, лавлагаа мэдээллээр иргэд, хуулийн этгээдийг хангах нэгдсэн зохицуулалт байдаггүй болно.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурал нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийг эдэлдэг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам батлахгүй.” гэж хуульчилсан. Дээрх зохицуулалтын “хуульд өөрөөр заагаагүй” гэсэн зохицуулалт нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хуулиар зөвшөөрсөн тохиолдолд Улсын Их Хурлын Байнгын хороо гаргаж болохоор заасан нь хууль тогтоох онцгой бүрэн эрх 126 гишүүдээс бүрдэх Улсын Их Хуралд хадгалагдах, засаглалын аливаа эрх мэдэл харилцан хяналттай байх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчим алдагдах болон хууль ёсны эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд шүүх эрх мэдлийн байгууллагад хандах иргэдийн эрх зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2 дахь заалтын дагуу хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн төрлөөр хуулийн төслийг боловсруулах бөгөөд дараах агуулгатай байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн тухай хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг тухайн байгууллагын дотоод бүтцийн нэгжид олгохыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Дээрх зохицуулалт уялдуулан, түүнчлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргах эрх хэмжээг хуулиар тусгайлан олгоогүй байхад тухайн актыг гаргаж, мөрдүүлсэн, эсхүл улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй мөрдүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой тодорхой зохицуулалтыг бий болгох;

- Захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хянаж бүртгэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн дагуу гомдол гаргахгүй байх, шүүхэд хянан шийдвэрлэхгүй байх зохицуулалтыг тус тус тусгах.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчим хангагдаж, иргэдийн хууль ёсны эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд шүүх эрх мэдлийн байгууллагад хандах боломжтой болно.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж , Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж заасантай захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхийг хуулийн дагуу эрх олгогдсон байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх хуулийн зохицуулалт бүрэн нийцэх болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрх 126 гишүүдээс бүрдэх Улсын Их Хуралд хадгалагдах, засаглалын аливаа эрх мэдэл харилцан хяналттай байх болно.

Мөн хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэл сайжирч, иргэдийн захиргааны хэм хэмжээний актыг олж авах, мэдэх эрх нь илүү хангагдах боломжтой болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулах болно.

----oO----